

Дундговь аймаг дахь  
Төрийн аудитын газар



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны  
санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудит

АУДИТЫН КОД:

ДУА-2023/01/НА-СТА-ТЕЗ

Дарга, тэргүүлэх аудитор:

Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг:

[Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг:

[Narantsatsralkh@audit.gov.mn](mailto:Narantsatsralkh@audit.gov.mn)

Ахлах аудитор Д.Ихбаяр

Цахим хаяг: [Ikhbayard@audit.gov.mn](mailto:Ikhbayard@audit.gov.mn)

Аудитор Д.Должинсүрэн

Цахим хаяг: [Doljinsurend@audit.gov.mn](mailto:Doljinsurend@audit.gov.mn)

Утас: 7059-3113

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим  
хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2023. 04. 20. № 151

тантай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дундговь аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд боловсрол, соёл, эрүүл мэндийн салбаруудын төсөвт байгууллагууд төсвийн шинэчлэлтэй холбоотой орон нутгийн төсвөөс 84,376.0 сая төгрөгийн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлсэн байна. Үүнд:

- Боловсрол шинжлэх ухааны яаманд 56,466.4 сая төгрөгийн хөрөнгө
- Эрүүл мэндийн яаманд 12,061.9 сая төгрөгийн хөрөнгө
- Соёлын яаманд 8,522.4 сая төгрөгийн хөрөнгө
- Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороонд 3,909.8 сая төгрөгийн хөрөнгө
- Барилга, хот байгуулалтын яаманд 565.2 сая төгрөгийн хөрөнгө
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2,850.3 сая төгрөгийн хөрөнгө

Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

3012020310

Төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

### **Аудитын гол асуудал**

Дундговь аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтэй холбоотой 383.7 сая төгрөгийн дараах зөрчил нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг буруу тайлагналын эрсдэл өндөр үнэлэгдсэн асуудал байлаа.

1. Орон нутгийн төсвөөс төсвийн шууд захирагч нарт хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс 17.7 сая төгрөгийн урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоож, Дундговь аймгийн 80 жилийн үйл ажиллагаанд зориулан үндсэн чиг үүрэгт хамааралгүй зардалд 194.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон зөрчлийн 60.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 134.0 сая төгрөгийг сумдад буцаан төлүүлэхээр авлага үүсгэж залруулсан.
2. Мөн бусад төсвийн байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 69.0 сая төгрөгийн бичиг хэрэг, шатахууны зардалд зарцуулсан зөрчилд албан шаардлага, 8.0 сая төгрөгийн бэлэг дурсгал, шаардлагагүй хөрөнгө бэлтгэсэн, хориглосон зардалд зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
3. СХДАА-наас ТЕЗ-ийн харьяа 8 байгууллагын 10 албан хаагчид хамаарал бүхий эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохиролтой холбоотой 95.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аймгийн Засаг даргын Засгийн газрын хэрэг эрхлэх газартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хийсэн үнэлгээгээр 92.9 хувиар үнэлэгдсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ



## 1. ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 1706

Монгол Улс

#### Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг"-ийн 1.1, 1.3, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 18 дугаар зүйлийн 9-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан"-д хийсэн аудитын тайланг /ДУА-2023/1/НА-СТА-ТЕЗ/-г нэг дүгээр хавсралтаар, аудитаар илэрсэн зөрчил, төсөв захирагчийн харьяа байгууллагад хүргүүлсэн төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. "Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан"-д хийсэн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

4. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан үр дүнгийн талаар 2023 оны 11 сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Ц.Мөнхбат/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Энхтайван/, Ерөнхий санхүүч /С.Адьяасүрэн/-д тус тус зөвлөсүгэй.

5. Аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2023 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын нэгдүгээр нэгжийн ахлах аудитор /Д.Ихбаяр/, аудитор /Д.Должинсүрэн/ нарт үүрэг болгосугай.

Р.МОНХТОГТОХ



**Агуулга**

1. ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ .....	1
1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
1. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.4.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө .....	12
3.4.2 Авлага.....	13
3.4.3 Бараа материал .....	14
3.4.4 Бусад эргэлтийн хөрөнгө.....	15
3.4.5 Үндсэн хөрөнгө .....	16
3.4.6 Өр төлбөр.....	17
3.4.7 Засгийн газрын хувь оролцоо .....	18
3.4.7 Орлогын данс .....	19
3.4.8 Зардал .....	19
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	20
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	21
4.1. Ерөнхий зүйл .....	21
4.2 Материаллаг байдал.....	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	22
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	23
5. Аудитын илрүүлэлт .....	23
4.1 Албан шаардлага.....	24
4.2 Зөвлөмж .....	25
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	27
6.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	28



## Товчилсон үгийн жагсаалт

<b>ААНБ</b>	<b>Аж ахуйн нэгж, байгууллага</b>
<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>АЗДТГ</b>	Аймгийн Засаг даргын Тамгын газар
<b>АОУС</b>	Аудитын Олон Улсын Стандарт
<b>БОАЖТ</b>	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
<b>ТХДЖТ</b>	Төв халхын дуулалт жүжгийн театр
<b>БХС</b>	Байгаль хамгаалах сан
<b>ТБОНӨХБАУХА</b>	Төрийн болон оро нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
<b>ГБХЗХГ</b>	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
<b>ОНӨГ</b>	Орон нутгийн өмчийн газар
<b>СХДАА</b>	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
<b>СДОА</b>	Сум дундын ойн анги
<b>ЗДТГ</b>	Засаг даргын Тамгын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчийн Хурал
<b>МХС</b>	Мал хамгаалах сан
<b>ОНӨААТҮГ</b>	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>ХХОАТ</b>	Хувь хүний орлогын албан татвар
<b>ХХС</b>	Хоршоо хөгжүүлэх сан
<b>ТЕЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>ТЗС</b>	Тусгай зориулалтын сан
<b>ТӨҮГ</b>	Төрийн өмчит үйлдвэрийн газар
<b>ТТЗ</b>	Төсвийн төвлөрүүлэн захирагч
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>ТШЗ</b>	Төсвийн шууд захирагч
<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
<b>ЭМТ</b>	Эрүүл мэндийн төв
<b>ЭЭС</b>	Эмийн эргэлтийн сан



## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р бие, Сайнгатан сум  
Дундговь аймэг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208. Цэвэр цаар: dundgoviaudit.gov.mn

2023.04.20 № 151  
төвий \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дундговь аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудитын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд боловсрол, соёл, эрүүл мэндийн салбаруудын төсөвт байгууллагууд төсвийн шинэчлэлтэй холбоотой орон нутгийн төсвөөс 84,376.0 сая төгрөгийн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлсэн байна. Үүнд:

- Боловсрол шинэчлэх ухааны яаманд 56,466.4 сая төгрөгийн хөрөнгө
- Эрүүл мэндийн яаманд 12,061.9 сая төгрөгийн хөрөнгө
- Соёлын яаманд 8,522.4 сая төгрөгийн хөрөнгө
- Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороонд 3,909.8 сая төгрөгийн хөрөнгө
- Барилга, хот байгуулалтын яаманд 565.2 сая төгрөгийн хөрөнгө
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2,850.3 сая төгрөгийн хөрөнгө

Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

0012020310





Төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

#### **Аудитын гол асуудал**

Дундговь аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилттэй холбоотой 383.7 сая төгрөгийн дараах зөрчил нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг буруу тайлагналын эрэдэл өндөр үнэлэгдсэн асуудал байлаа.

1. Орон нутгийн төсвөөс төсвийн шууд захирагч нарт хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс 17.7 сая төгрөгийн урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоож, Дундговь аймгийн 80 жилийн үйл ажиллагаанд зориулан үндсэн чиг үүрэгт хамааралгүй зардалд 194.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон зөрчлийн 60.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 134.0 сая төгрөгийг сумдад буцаан толүүлэхээр авлага үүсгэж зарлуулсан.
2. Мөн бусад төсвийн байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 69.0 сая төгрөгийн бичиг хэрэг, шатахууны зардалд зарцуулсан зөрчилд албан шаардлага, 8.0 сая төгрөгийн бэлэг дурсгал, шаардлагагүй хөрөнгө бэлтгэсэн, хориглосон зардалд зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
3. СХДАА-наас ТЕЗ-ийн харьяа 8 байгууллагын 10 албан хаагчид хамаарал бүхий эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохиролтой холбоотой 95.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аймгийн Засаг даргын Засгийн газрын хэрэг эрхлэх газартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хийсэн үнэлгээгээр 92.9 хувиар үнэлэгдсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**



Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлгээг санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТӨГТӨХ



**1. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/Мянган төгрөг/	
			2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>37,384,564.0</b>	<b>33,357,548.4</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	11,548,772.2	10,531,229.7
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	7,816,154.8	5,666,295.1
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	9,044,393.2	4,163,309.4
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	176,077.0	93,750.1
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	8,799,166.8	12,902,964.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>161,537,291.2</b>	<b>92,658,324.2</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	161,537,291.2	92,658,324.2
39200	Биет хөрөнгө		134,754,434.9	68,493,624.8
39300	Биет бус хөрөнгө	13	26,782,856.2	24,164,699.4
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>198,921,855.2</b>	<b>126,015,872.5</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>13,845,425.7</b>	<b>16,669,040.1</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	1,690,110.2	1,354,354.0
41300	Өглөг	17а, 17б	1,097,189.2	762,210.9
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	592,921.0	592,143.1
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		12,155,315.5	15,314,686.1
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	12,155,315.5	15,314,686.1
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>185,076,429.5</b>	<b>109,346,832.4</b>
51	Засгийн газрын хувь оролцоо		185,076,429.5	109,346,832.4
51100	Засгийн газрын оруулсан капитал		74,794,381.5	41,921,503.7
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		0.0	41,921,503.7
51200	Хуримтлагдсан үр дүн		63,329,939.2	39,740,175.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		46,952,108.9	27,685,153.4
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>198,921,855.2</b>	<b>126,015,872.5</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/Мянган төгрөг/	
			2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>163,918,157.4</b>	<b>47,132,991.4</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО		7,743,307.5	8,971,191.9
110	Орлогын албан татвар		4,737,544.4	5,363,400.0
1100	Хувь хүний орлогын албан татвар		5,020,658.6	5,652,018.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-283,114.2	-361,298.4
1103	ААН-ын орлогын албан татвар		0.0	72,679.7
113	Хөрөнгийн албан татвар		1,184,143.5	1,538,022.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж		1,821,619.5	2,069,769.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	79,592,785.0	31,107,735.2
120	Нийтлэг татварын бус орлого		33,632,690.4	11,247,615.3
121	Хөрөнгийн орлого		108,801.8	48,665.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		45,851,292.8	19,811,454.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		76,582,064.9	7,054,064.3
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	2а, 2б	<b>134,678,405.1</b>	<b>30,324,252.0</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ		134,678,405.1	30,324,252.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		64,397,436.3	21,867,214.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		29,070,623.1	5,584,127.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3,769,815.4	687,420.6



2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,837,471.4	707,724.8
2104	Хангамж, бараа материалын зардал	2,610,187.2	1,573,074.8
2105	Нормативт зардал	4,530,032.3	86,362.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	821,025.7	263,095.0
2107	Томилолт, зочны зардал	227,127.3	231,704.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,851,316.9	2,037,977.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,679,836.9	10,695,728.0
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	1,186,801.6	873,582.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,094,167.2	7,583,455.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	29,239,752.3	16,808,739.4
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	784.3	1,006.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	9,164,403.4	90,376,307.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	20,076,133.1	-73,566,562.3

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>136,925,997.6</b>	<b>43,894,240.6</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	7,798,798.9	9,329,996.4
110	Орлогын албан татвар	4,742,544.4	5,666,720.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	5,025,658.6	5,652,018.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-283,114.2	-361,298.4
1103	ААН-ын орлогын албан татвар	0.0	376,000.0
113	Хөрөнгийн албан татвар	1,184,143.5	1,538,022.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,872,110.9	2,125,254.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	370,358.1	378,501.1
1181	Газрын төлбөр	605,158.6	693,027.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	896,594.3	1,053,725.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,691,474.2	27,320,378.2
120	Нийтлэг татварын бус орлого	8,731,379.6	7,460,258.3
121	Хөрөнгийн орлого	108,801.8	48,665.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	45,851,292.8	19,811,454.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	74,435,724.5	7,243,866.0
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>122,555,532.7</b>	<b>27,579,144.1</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	122,555,532.7	27,579,144.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	52,721,790.7	25,319,647.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,642,533.0	7,373,052.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,845,642.7	924,876.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,038,460.1	5,584,466.7
2104	Хангамж, бараа материалын зардал	3,452,321.0	2,780,964.3
2105	Нормативт зардал	2,722,728.6	189,142.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,151,735.2	670,713.4
2107	Томилолт, зочны зардал	225,440.3	233,354.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,142,672.4	1,855,066.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,500,257.4	5,708,011.0
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	661,089.4	855,397.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,172,652.6	1,404,099.2
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>14,370,464.9</b>	<b>16,315,096.5</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>10,702,380.4</b>	<b>16,223,325.1</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,702,380.4	16,223,325.1
2200	Дотоод эх үүсвэрээр	10,702,380.4	16,223,325.1



VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-10,702,380.4	-16,223,325.1
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-851,576.9	-1,109,313.9
14	Бусад эх үүсвэр	0.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГ ДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	851,576.9	1,109,313.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,816,507.6	-1,017,542.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,732,264.7	11,548,772.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,548,772.2	10,531,229.7

#### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	163,344,798.4	163,344,798.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,592,148.6	1,592,148.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,936,947.1	164,936,947.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-92.0	-92.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	10,800.0	10,800.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	52,641.3	52,641.3
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	20,076,133.1	20,076,133.1
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	185,076,429.5	185,076,429.5
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	185,076,429.5	185,076,429.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-3,716,016.8	-3,716,016.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	181,360,412.7	181,360,412.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-609.3	-609.3
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-2,007,344.7	-2,007,344.7
17	Өмчид гарсан өөрчлөлт	1,208,350.2	1,208,350.2
19	Тайлант үеийн үр дүн	-73,566,562.3	-73,566,562.3
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	109,346,832.4	109,346,832.4

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,864,902.6	32,957,164.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,543,915.8	20,744,429.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,452,822.9	19,730,512.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,821,079.5	6,632,802.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	860,248.6	809,932.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,415,656.6	5,343,440.1
2104	Хангамж, бараа материалын зардал	620,877.9	599,559.9
2105	Нормативт зардал	95,143.1	86,341.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	713,878.4	689,545.3
2107	Томилолт, зочны зардал	197,062.3	190,450.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,608,074.8	1,579,301.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,120,801.7	3,799,138.3
212	ТАТААС	122,000.0	112,000.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	80,000.0	70,000.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	42,000.0	42,000.0



213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	969,092.9	901,917.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	969,092.9	901,917.2
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,535,533.7</b>	<b>11,103,421.7</b>
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,785,453.1	1,109,313.9
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>40,864,902.6</b>	<b>33,325,238.9</b>
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,875,341.6	7,870,204.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24,164,825.0	23,080,666.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,824,736.0	2,374,368.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	7,525,958.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,597,400.9

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,525,170.6</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,765,462.7</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,468,861.7</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,896.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,280.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,932.0
2104	Хангамж, бараа материалын зардал	85,876.8
2105	Нормативт зардал	140.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	121,668.3
2107	Томилолт, зочны зардал	41,409.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	199,655.4
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,932,003.0</b>
210901	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,869,826.4</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	62,176.6
212	ТАТААС	8.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	8.0
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	8.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	296,592.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,501.7
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	254,091.3
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>759,707.9</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	759,707.9
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,460,435.0</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,460,435.0
III	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>(64,735.6)</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	64,745.2
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9.6



### **3. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дундговь аймгийн Засаг дарга нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг орон нутагт хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах эрх бүхий төсвийн ерөнхийлөн захирагч юм.

Дундговь аймгийн Засаг дарга нь эрхэм зорилгоо “Төр иргэн хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд ил тод байдлыг ханган хүн амын эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж байгалийн тэнцвэрт байдлыг хангана” гэж тодорхойлжээ.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Тайлант хугацаанд төсвийн шинэчлэлтэй холбоотой орон нутгаас санхүүждэг зарим төсөвт байгууллага нь улсын төсөвт шилжиж, улсын болон орон нутгийн төсвөөс тус тус санхүүжилт авдаг болж өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна гэж дүгнэлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2022 онд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 86 байгууллагад дотоод аудит болон санхүүгийн хяналт шалгалт хийгдэж, 2 байгууллагад 4 удаагийн 2,518.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож хэрэгжилт 72 хувьтай ба акт тооцох хугацаа болоогүй, 6 байгууллагад 135,186.0 мянган төгрөгийн хугацаатай албан шаардлага өгснөөс хэрэгжилт 100 хувь, давхардсан тоогоор 78 байгууллагад 113 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 92 хувьтай.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дундговь аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт орсон байна. Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүждэг болон орон нутгийн орлогоос санхүүждэг байсан байгууллагууд улсын төсөв буюу холбогдох яамдаасаа санхүүждэг болсон байна. Нэгтгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой төсөвт байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайлан буюу хөрөнгийг орон нутгийн



төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчид шилжүүлэн өгсөн байна. Дээрх байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан байна.

Дундговь аймгийн Засаг даргын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 72,906.0 мянган төгрөгөөр буюу 36.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт №1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Балансын үзүүлэлт	Тайлант оны эхний үлдэгдэл	Тайлант оны эцсийн үлдэгдэл	Зөрүү	
			Өсөлт /+/, бууралт /-/	Хувь
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>37,384.6</b>	<b>33,357.5</b>	-4,027.1	(10.8)
Мөнгөн хөрөнгө	11,548.8	10,531.2	-1,017.6	(8.8)
Авлага	7,816.2	5,666.3	-2,149.9	(27.5)
Бараа материал	9,044.4	4,163.3	-4,881.1	(54.0)
Нөөцийн бараа	176.1	93.8	-82.3	(46.7)
Бусад эргэлтийн хөрөнгө	8,799.2	12,903.0	4,103.8	46.6
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>161,537.3</b>	<b>92,593.9</b>	<b>-68,943.4</b>	<b>(42.7)</b>
<b>Үндсэн хөрөнгө</b>	<b>161,537.3</b>	<b>92,658.3</b>	<b>-68,879.0</b>	<b>(42.6)</b>
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>198,921.9</b>	<b>126,015.9</b>	<b>-72,906.0</b>	<b>(36.7)</b>
Нийт өр төлбөр	13,845.4	16,669.0	2,823.6	20.4
Богино хугацаат өр төлбөр	1,690.1	1,354.4	-335.7	(19.9)
Урт хугацаат өр төлбөр	12,155.3	15,314.7	3,159.4	26.0
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	185,076.4	109,346.8	-75,729.6	(40.9)
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>185,076.4</b>	<b>109,346.8</b>	<b>-75,729.6</b>	<b>(40.9)</b>
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>198,921.9</b>	<b>126,015.9</b>	<b>-72,906.0</b>	<b>(36.7)</b>

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад ихэнх дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тодруулбал: Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,017.6 сая, авлага 2,149.9 сая, бараа материал 4,881.1 сая, үндсэн хөрөнгө 68,879.0 сая төгрөгөөр тус тус буурч, бусад эргэлтийн хөрөнгө 4,103.8 сая, өр төлбөр 2,823.6 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Дээрх өөрчлөлтүүд нь тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүждэг байсан Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, орон нутгийн төсвөөс санхүүждэг байсан сумын Соёлын төвүүд, Музей, Номын сан, ГХДЖТ, Тэнгэрийн тэмдэг, ГБХЗХГ зэрэг төсвийн байгууллагууд харьяалагдах яамдаасаа санхүүжилтээ авч, санхүүгийн тайлангаа яамдад нэгтгүүлдэг болсон нь нөлөөлсөн байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 11,548.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 10,531.2 сая төгрөг болж, 1,017.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.07	0.1	0.03
Банканд байгаа бэлэн мөнгө	11,467.3	10,402.3	-1,065.0
Замд яваа мөнгөн хөрөнгө	81.4	128.8	47.4
Хадгаламж	-	-	-
<b>Дүн</b>	<b>11,548.8</b>	<b>10,531.2</b>	<b>-1,017.6</b>
<i>Үүнээс, байгууллагын торлоор</i>			
Төсөвт байгууллага	6,135.1	5,829.9	-305.2
Төсөл/ сан	1,827.6	2,009.9	182.3

ДУА-2023/1/НА-СТА-ТЕЗ





Төрийн сан	3,408.1	2,632.3	-775.8
ТӨҮГ болон ОНӨААТҮГ	178.0	59.2	118.8
<b>Дүн</b>	<b>11,548.8</b>	<b>10,531.2</b>	<b>-1,017.6</b>

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 41.6 хувь нь төсөвт байгууллага, 30.8 хувь нь төсөл сан, 25.1 хувь нь Төрийн сан, 2.5 хувь нь ОНӨААТҮГ-ын үлдэгдэл байна.

Харилцах дансны үлдэгдэл буурсан шалтгаан нь улсын төсвийн байгууллагын ахмадын сангийн үлдэгдэл 284.6 сая төгрөг, ЭМТ-үүдийн 2021 оны харилцах дансны үлдэгдэл 142.4 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилгын барьцаа хөрөнгөөс 350.3 сая төгрөг, барьцаа хөрөнгөнд байршуулсан 13.1 сая төгрөгийг холбогдох яам руу шилжүүлэн, Сайнцагаан, Сайхан-Овоо, Баянжаргалан сумдын ОНХС-ийн өмнөх оны үлдлийн 565.2 сая төгрөгийг зарцуулсантай тус тус холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгийн данстай холбоотой нийт 770.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:

- Сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 677.5 сая төгрөгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа ТБОНӨХБАУХА тухай хууль зөрчсөн. / Аймгийн ОНХС 118.9 сая, Дэрэн сумын ОНХС 59.4 сая, Өндөршил сумын ОНХС 36.0, Хулд сумын ОНХС 50.0, Цагаандэлгэр сумын ОНХС 40.0, Эрдэнэдалай сумын ОНХС 80.2 сая, Эрдэнэдалай сумын ТЗС 40.0 сая, Дундговь-Ус ОНӨААТҮГ 183.0 сая, Аймгийн ЗДТГ 70.0 сая /
- Зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авалт хийсэн. /Хулд сумын ОНХС 4 сая /
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хангалтгүй баримтаар 45.5 сая төгрөгийн гүйлгээ гаргасан. /Дэрэн сумын ЗДТГ 14.9 сая, Дэрэн сумын ТЗС 5.3 сая, Хулд сумын ИТХ 1.3 сая, БОАЖГ 12.4 сая, ОНӨГ 3.4 сая, Цагаандэлгэр сумын ИТХ 2.0 сая, Хулд сумын ЗДТГ 5.7 сая/
- Мөнгөн гүйлгээний тайланг 43.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. /Баянжаргалан сумын ЗДТГ 9.4 сая, Өлзийт сумын ЭЭС 29.9 сая, Боржигон мандал өрхийн эмнэлэг 0.7 сая, Өлзийт мандал өрхийн эмнэлэг 3.8 сая/

Шийдвэрлэсэн нь: 64.1 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 9.7 сая төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 677.9 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлэн, 19.2 сая төгрөгийн зөвлөмж өгсөн байна.

#### 3.4.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 7,816.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,666.3 сая төгрөг болж, 2,149.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Авлага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөл (+), Буурал (-)
Ажилчидтай холбогдсон авлага	16.8	11.6	-5.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	2,147.1	6.3	2,140.8
Дансны авлага / ОНӨААТҮГ /	394.4	259.5	-134.9
Татвар НДШ / ОНӨААТҮГ /	1.6	2.8	1.2
Байгууллагаас авах авлага	2,290.0	2,566.4	276.4
Хувь хүмүүсээс авах авлага	410.7	390.1	-20.6
Зээлийн хүүгийн авлага	22.6	16.3	-6.3
ЗГ бусад шатны төсөвт олгосон зээл	-	-	-
Хувь хүмүүст олгосон зээл	1,792.1	1,340.1	-452.0
Хувийн хэвшлийн ААНБ олгосон зээл	740.8	1,073.1	332.3
<b>Дүн</b>	<b>7,816.1</b>	<b>5,666.3</b>	<b>-2,149.8</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	4,724.3	2,821.8	1,902.5
Төсөл/ сан	2,672.4	2,560.7	111.7
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨААТҮГ	419.4	283.8	135.6
<b>Дүн</b>	<b>7,816.1</b>	<b>5,666.3</b>	<b>-2,149.8</b>



Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдлийн 49.8 хувь нь төсөвт байгууллага, 45.2 хувь нь төсөл сан, 5.0 хувь нь ОНӨААТҮГ-ын үлдэгдэл байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 2,149.8 сая төгрөгөөр буурсан нь сумдын ЭМТ-үүдийн эрүүл мэндийн даатгалын сангаас орох цар тахлын эмчилгээний 2,140.8 сая төгрөгийн авлага болон улсын төсвийн байгууллагуудын 44.3 сая төгрөгийн авлагыг тус тус холбогдох яам руу шилжүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт авлагын 4.0 хувь буюу 224.1 сая төгрөг нь 5 жилээс дээш насжилттай авлага байгаа бөгөөд үүнээс эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохиролтой холбоотой үүсэн авлага тодорхой хувийг эзэлж байна.

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар санхүүгийн аудит хийсэн нийт төсөвт байгууллагын хэмжээнд 21 албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалин 150.3 сая төгрөгийг төсвөөс олгож санхүүгийн тайланд авлагаар тусгаж тайлагнасан байна. Үүнээс ТЕЗ-ийн харьяа байгууллагад хамаарал бүхий 10 албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалинг олгосон 95.0 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Өмнөх оны Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын үр дүнгээр 5 албан хаагчид хамаарал бүхий 20.0 сая төгрөгийн төрд учирсан хохирлыг барагдуулах арга арга хэмжээ авч хариу ирүүлэх чиглэлийг аймгийн СХДАА-нд хүргүүлсэн боловч хэрэгжээгүй байна. Насжилт өндөртэй дээрх авлага нь эргэн төлөгдөхгүй, найдваргүй болох эрсдэлтэй байна.

#### Аудитын илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд авлагын данстай холбоотой нийт 430.7 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:

- Авлагын 125.6 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй. / Адаацаг сумын МХС 20.8 сая, Сайхан-Овоо сумын ЭЭС 19.2 сая, Хот тохижуулах газар 2.1 сая, Дэлгэрцогт сумын ЗДТГ 1.1 сая, Өндөршил сумын ОНХС 5.4 сая, Хулд сумын ХХС 22.3 сая, Цагаандэлгэр сумын ЗДТГ 5.0, Дэрэн сумын ТЭС 28.0 сая, Дэлгэрцогт сумын ТЭС 10.1 сая, Цагаандэлгэр 3.2 сая, Дэрэн сумын ОНХС 8.0 сая /
- Санхүүгийн тайланд 177.6 сая төгрөгийн авлагыг тусгаагүй, илүү, дутуу зөрүүтэй тайлагнасан / Гурвансайхан сумын ОНХС 20.0 сая, Дэлгэрхангай сумын ОНХС 20.0, Дэлгэрцогт сумын ОНХС 10.0, Өндөршил сумын ОНХС 19.9 сая, Сайхан-Овоо сумын ОНХС 5.0 сая, Сайнцагаан сумын ОНХС 19.8 сая, Хулд сумын ОНХС 19.3 сая, Эрдэнэдалай 20.0 сая, Адаацаг сумын ЗДТГ 6.0 сая, Хулд сумын МХС 11.0 сая, Дундговь ус ОНӨАТҮГ 10.1 сая, Эрдэнэдалай сумын ЗДТГ 3.4 сая, Аймгийн ЗДТГ 2.8 сая, Баянжаргалан сумын ЭЭС 4.9 сая, Хулд сумын ЗДТГ 3.3 сая /
- Хоршоо хөгжүүлэх сангийн 127.5 сая төгрөгийн хугацаа хэтрэлттэй зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдээгүй / Цагаандэлгэр сумын ХХС 8.6 сая, Гурвансайхан сумын ХХС 24.8 сая, Хулд сумын ХХС 14.2 сая, Адаацаг сумын ХХС 6.6 сая, Дэлгэрцогт сумын ХХС 7.4 сая /

Шийдвэрлэсэн нь: Авлагын данстай холбоотой дээрх зөрчлүүдийн 41.5 сая төгрөгийн авлагыг барагдуулах зөвлөмж өгч, 138.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 81.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 169.3 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулсан.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 9,220.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,257.1 сая төгрөг болж, 4,963.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	2,209.9	198.6	-2,011.3
Эм боох материал	928.9	327.4	-6,01.5

ДУА-2023/1/НА-СТА-ТЕЗ



Бэлэн бүтээгдэхүүн	6.1	6.1	
Бичиг хэргийн материал	318.6	49.0	-269.6
Аж ахуйн материал	3,551.3	2,229.0	-1,322.3
Сэлбэг хэрэгсэл	75.2	105.2	-30.0
Түлш, шатах тослох материал	70.1	156.4	86.3
Барилгын засварын материал	218.9	116.8	-102.1
Хүнсний материал	168.8		-168.8
Бусад хангамжийн материал	472.6	577.4	104.8
Мал амьтад	1,024.0	397.4	-626.6
Нөөцийн бараа	176.1	93.8	-82.3
Дүн	9,220.5	4,257.1	-4,963.4
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	8,225.6	2,936.6	-5,289.1
Төсөл/ сан	299.6	251.4	-48.2
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨААТҮГ	695.4	1,069.1	373.7
Дүн	9,220.5	4,257.1	-4,963.4

*Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант оны эцэст 4,764.6 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, үнэ төлбөргүй буюу хандиваар 546.5 сая төгрөг, шилжүүлэн авсан 175.9 сая төгрөг, бусад 423.1 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 37.1 сая төгрөгийн бараа материалаар нэмэгдэж, 10,910.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, шилжүүлсэн байна. Бараа материалын зарцуулалтын 45.9 хувь буюу 5,004.3 сая төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн бараа материал эзэлж байгаа бөгөөд энэ нь бараа материалын бууралтад нөлөөлсөн байна.

Нийт бараа материалын үлдэгдлийн 74.9 хувь нь төсөвт байгууллага болон төсөл сан, 25.1 хувь нь ОНӨААТҮГ-т байршиж байна.

#### Аудитын илрүүлэлт:

*Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд бараа материалын данстай холбоотой нийт 1,300.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:*

- Санхүүгийн тайланд 422.0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй, буруу тайлагнасан / Дэрэн сумын ТЗС 6.3 сая, Говь-Угтаал сумын ОНХС 178.9 сая, Сайнцагаан сумын Луус сумын ОНХС 1.1 сая, Өндөршил сумын ЗДТГ 43.5 сая, Сайхан-Овоо сумын ОНХС 115.7 сая, Хулд сумын МХС 30.0 сая, Өлзийт сумын ЭЭС 33.3 сая, Аймгийн ЗДТГ 12.1 сая /
- Бараа материалын үлдэгдлийг тооллого хийж баримтжуулаагүй /Дэрэн сумын ТЗС 0.6 сая/
- Малжуулах төслийн 855.3 сая төгрөгийн малыг сумын ОНХС-ийн бараа материалын дансанд бүртгэсэн. /Адаацаг сумын ОНХС 100.0 сая, Дэлгэрхангай сумын ОНХС 133.5 сая, Дэлгэрцогт сумын ОНХС 45.0 сая, Дэрэн сумын ОНХС 136.4 сая, Луус сумын ОНХС 30.0, Өлзийт сумын ОНХС 163.3 сая, Сайнцагаан сумын ОНХС 127.2 сая, Хулд сумын ОНХС 80.0 сая, Цагаандэлгэр сумын ОНХС 40.0 сая /
- Анхан шатны баримт бүрдэл дутуу баримтаар 22.4 сая төгрөгийн бараа материал зарцуулсан. /Дэрэн сумын ЗДТГ 2.8 сая, Эрдэнэдалай сумын ИТХ 8.5 сая, Говь-Угтаал сумын ЗДТГ 9.9 сая, Сайхан-Овоо сумын 1.0 сая /

*Шийдвэрлэсэн нь: Бараа материалын данстай холбоотой дээрх зөрчлүүдэд 0.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 12.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 12.1 сая төгрөгийн зөвлөмж өгч, 1,275.2 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулсан.*

#### 3.4.4 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,799.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 12,903.8 сая төгрөг болж, 4,103.8 сая төгрөгөөр өссөн байна.



Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө	8,799.2	12,903.0	4,103.8
Дүн	8,799.2	12,903.0	4,103.8
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	723.2	1,536.3	813.1
Төсөл/ сан			
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨААТҮГ	8,075.9	11,366.7	3,290.8
Дүн	8,799.2	12,903.0	4,103.8

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгийн дансны өсөлт нь аймгийн төвд шинээр баригдаж байгаа “Цэвэрлэх байгууламж” -ийн тайлант оны гүйцэтгэлийн 3,290.8 сая төгрөг, аймаг, сумын ОНХС болон ОНХО-аар санхүүжүүлсэн 813.1 сая төгрөгийн сумын хөгжлийн төлөвлөгөө болон төсөл арга хэмжээний зураг төсвийн бүртгэлтэй холбоотой байна.

Бусад эргэлтийн хөрөнгийн дансны үлдэгдлийн 11.9 хувь нь төсөвт байгууллага, 88.1 хувийг ОНӨААТҮГ-т байршиж байна.

### 3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 190,588.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 113,973.8 сая төгрөг болж 76,614.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	131,933.4	73,372.5	-58,560.9
Тээврийн хэрэгсэл	7,332.6	5,486.3	-1,846.3
Машин тоног төхөөрөмж	13,639.8	6,686.3	-6,953.5
Тавилга эд хогшил	5,941.1	1,799.6	-4,141.5
Дуусаагүй барилга	2,228.4	365.5	-1,862.9
Түүх соёлын дурсгалт зүйл	932.0	6.5	-925.5
Номын фонд	714.5	0.2	-714.3
Биет бус хөрөнгө	26,946.90	24,314.1	-2,632.8
Бусад үндсэн хөрөнгө	919.4	1,942.8	1,023.4
Дүн	190,588.1	113,973.8	-76,614.3
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	151,765.5	79,202.8	-72,563
Төсөл/ сан	17.4	7.6	-9.8
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨААТҮГ	38,805.2	34,763.4	-4,041.8
Дүн	190,588.1	113,973.8	-76,614.3

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийн 69.5 хувийг төсөвт байгууллага, төсөл сан, 30.5 хувийг ОНӨААТҮГ-ын хөрөнгийн үлдэгдэл эзэлж байна. Нийт хөрөнгийн 78.7 хувийг биет хөрөнгө, 21.3 хувийг газар болон биет бус хөрөнгө эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгө 897.5 сая төгрөг, үнэ төлбөргүй буюу хандиваар авсан 1,991.1 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 1,927.6 сая төгрөг, бусад 9,652.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, 91,082.6 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, акталж данснаас хассан байна. Үндсэн хөрөнгийн зарцуулалтын 84,375.9 сая төгрөг буюу 92.6 хувийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн үндсэн хөрөнгө эзэлж байгаа бөгөөд энэ нь үндсэн хөрөнгийн бууралтад нөлөөлсөн байна.

Дуусаагүй барилга дансанд Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрын 365.5 сая



төгрөгийн цэвэр усны шугам сүлжээний барилгын санхүүжилтийн эх үүсвэр дутагдсантай холбоотой хөрөнгө бүртгэлтэй байна.

**Аудитын илрүүлэлт:**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн данстай холбоотой нийт 260.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:

- 221.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаагүй, зөрүүтэй дүнгээр тусгасан. /Хулд сумын ОНХС 30.0 сая, Адаацаг сумын ЗДТГ 41.9 сая төгрөг, Говь-Угтаал сумын ЗДТГ 46.8 сая, Дэлгэрхангай сумын ЗДТГ 3.6 сая, Луус сумын ЗДТГ 30.0 сая, Өндөршил сумын ЗДТГ 68.5 сая, Баянжаргалан сумын ЭЭС 0.8 сая /
- Биетээр байхгүй хөрөнгийг бүртгэн, хөрөнгө дутааж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавиагүй /Адаацаг сумын ЗДТГ 3.5 сая, Өлзийт сумын ЗДТГ 3.5 сая, Сайхан-Овоо сумын ЗДТГ 0.5 сая, Хулд сумын ЗДТГ 6.7 сая, Дэрэн сумын Эрдэм шинжилгээний төв 19.5 сая, Дэрэн сумын ЗДТГ 5.0 сая /
- Үндсэн хөрөнгийг албан хаагчдад хариуцуулахдаа эд хариуцагчийн гэрээ хийж, дүгнээгүй. /Өлзийт сумын ЗДТГ, Дэрэн сумын ЗДТГ/

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгөтэй холбоотой дээрх зөрчлүүдэд 0.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 68.3 сая төгрөгийн албан шаардлага өгч, 191.6 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан.

**3.4.6 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл **13,845.4** сая, эцсийн үлдэгдэл **16,669.0** сая төгрөг болж, **2,823.6** сая төгрөгөөр өссөн байна. Нийт өр төлбөрийн өсөлт нь дамжуулан зээл буюу аймгийн төвд шинээр баригдаж байгаа “Цэвэрлэх байгууламж” -ийн тайлант оны гүйцэтгэлийн 3,159.4 сая төгрөгийн зээлийн өсөлттэй холбоотой байна.

Хүснэгт № 5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үдүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн /+/, Буурсан/-/
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>	<b>1,690.1</b>	<b>1,354.3</b>	<b>-335.8</b>
Өглөг	1,690.1	1,354.3	-335.8
Ажилчидтай холбогдсон өглөг	80.3	11.4	-68.9
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг			
Бараа үйлчилгээний зардлын өглөг	403.8	109.8	-294.0
Зээлийн хүүгийн өглөг	0.3	0.3	0.00
Бусад өглөг	612.7	640.7	28.00
Урьдчилж орсон орлого	593.0	592.1	-0.90
<b>Урт хугацаат өр төлбөр дүн</b>	<b>12,155.3</b>	<b>15,314.7</b>	<b>3,159.4</b>
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	12,155.3	15,314.7	3,159.4
<b>Нийт дүн</b>	<b>13,845.4</b>	<b>16,669.0</b>	<b>2,823.6</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	3,261.9	817.4	-2,444.50
Төсөл, сан	90.0	64.5	-25.50
Төрийн сан		15,618.0	15,618.0
ТӨҮГ болон ОНӨААТҮГ	10,493.5	169.1	-10,324.4
<b>ДҮН</b>	<b>13,845.4</b>	<b>16,669.0</b>	<b>2,823.6</b>

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст 1,354.3 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөр бүртгэгдсэний 47.3 хувь нь бусад өр төлбөр, 8.1 хувь нь бараа үйлчилгээний зардлын өр төлбөр, 0.8 хувь нь ажилчидтай холбогдсон өр төлбөр, 43.8 хувь нь урьдчилж орсон орлого, 0.02 хувь нь зээлийн хүүгийн өр төлбөр байна.

Богино хугацаат өр төлбөрийн дүнд **352.5** сая төгрөгийн насжилт өндөртэй, материаллаг дүнтэй дараах өр төлбөр байна. Үүнд:

- Цагаандэлгэр сумын ЭЭС-ийн 18.8 сая төгрөгийн эмийн өр;
- Цагаандэлгэр, Говь-Угтаал сумын Мал хамгаалах сангийн 20.0 сая төгрөгийн өвсний өр;



- Говь-Угтаал, Хулд сумдын Байгаль хамгаалах сангийн 29.9 сая төгрөгийн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн өр;
- Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилгын барьцаа хөрөнгийн 227.0 сая төгрөг өр;

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын Азийн хөгжлийн банкны “Нийтийн аж ахуйг хөгжүүлэх төсөл”-тэй холбоотой 2,191.9 сая төгрөг, Азийн хөгжлийн банкнаас хэрэгжиж буй цэвэрлэх байгууламжийн төслийн 11,235.3 сая төгрөг, Гурвансайхан суманд Азийн хөгжлийн банкны санхүүжилтаар хэрэгжсэн “Хот байгуулалтын салбарын төсөл”-ийн хүрээнд үүссэн 1,887.5 сая төгрөг, нийт 15,314.7 сая төгрөгийн өр байна. Тайлант онд урт хугацаат өр төлбөрөөс зээлийн хүүгийн төлбөрт Засаг дарга сангаас 18.0 сая, Орон ерөнхий орлогын данснаас үндсэн зээлийн төлбөрт 131.4 сая төгрөг буюу нийт 149.4 сая төгрөг төлөгдсөн байна.

**Аудитын илрүүлэлт:**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд өр төлбөрийн данстай холбоотой нийт 68.5 сая төгрөгийн зөрчлүүд илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:

- Санхүүгийн тайлан дахь өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй /Эрдэнэдалай сумын ЭЭС 13.2 сая, Дэлгэрцогт сумын БХС 1.0 сая, Сайхан-Овоо сумын ТЗС 1.6 сая/
- Өглөгийг бүртгэж тайлагнаагүй. /Баянжаргалан сумын ЭЭС 5.0 сая, Дундговь ус ОНӨААТҮГ 1.8 сая, Дэлгэрхангай сумын БХС 0.5 сая, Дэлгэрцогт сумын ИТХ 0.7 сая, Өлзийт сумын ТЗС 0.8 сая, Сайнцагаан сумын ТЗС 3.0 сая/
- Өглөгийг зөрүүтэй тайлагнасан. /Луус сумын БХС 2.0 сая, Эрдэнэдалай сумын ЭЭС 23.0 сая, Дундговь ус ОНӨААТҮГ 11.1 сая, Цагаандэлгэр сумын МХС 5.0 сая/

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөртэй холбоотой дээрх зөрчлүүдэд 22.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 46.1 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулсан.

**3.4.7 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 185,076.4 сая, эцсийн үлдэгдэл 109,346.8 сая төгрөг болж 75,729.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 7 Засгийн газрын оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
ЗГ-ын оруулсан капитал	74,794.4	41,921.5	-32,872.9
Хуримтлагдсан үр дүн	63,329.9	39,740.2	-23,589.7
Өмнөх үеийн үр дүн	43,253.8	113,306.7	70,052.9
Тайлан үеийн үр дүн	20,076.1	-73,566.6	-93,642.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	46,952.1	27,685.2	-19,266.9
<b>Дүн</b>	<b>185,076.4</b>	<b>109,346.8</b>	<b>-75,729.6</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	143,306.9	68,306.9	-75,000.0
Төсөл, сан	4,718.2	4,765.1	46.9
Төрийн сан	3,408.1	2,460.5	-947.6
ТӨҮГ болон ОНӨААТҮГ	33,643.2	33,814.3	171.1
<b>Дүн</b>	<b>185,076.4</b>	<b>109,346.8</b>	<b>-75,729.6</b>

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсан нь тайлант оны нийт үр дүнгээс шалтгаалжээ.



### 3.4.7 Орлогын данс

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 1,213.5 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогыг 732.3 сая төгрөг, нийт 1,945.8 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 1,401.7 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 1,032.9 сая төгрөг, нийт 2,434.6 сая төгрөгөөр тайлагнажээ.

Тайлант хугацаанд 7,996.3 сая төгрөгийн татварын болон татварын бус орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 9,330.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 1,333.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөө биелсэн нь дараах 3 нэр төрлийн орлогын гүйцэтгэлээс шалтгаалсан байна. Үүнд:

- Байгалийн нөөц ашигласны төлбөр 3.5 дахин;
- Ан амьтны нөөц ашигласны төлбөр 3.3 дахин
- Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр 4.1 дахин давж биелсэн байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд орлогын данстай холбоотой нийт 723.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:*

*- Орлогыг илүү дутуу зөрүүтэй тайлагнасан./Сайхан-Овоо сумын ЭЭС 12.3 сая, Хулд сумын ЭЭС 17.4 сая Аймгийн ЗДТГ 7.0 сая, Сайнцагаан сумын ЗДТГ 14.9 сая, Эрдэнэдалай сумын ЭЭС 36.9 сая, Сайнцагаан сумын ЭЭС 1.6 сая, Говь-Угтаал сумын ЭЭС 21.9, Дэлгэрцогт сумын ЭЭС 4.6 сая, Баянжаргалан сумын ЭЭС 41.2 сая төгрөг, /*

*- Татварын болон татварын бус орлогыг дутуу төвлөрүүлсэн. /Аймгийн ЗДТГ 0.5 сая, Сайнцагаан сумын ЗДТГ 1.8 сая, Сайнцагаан сумын ЭЭС 1.7 сая, Говь-Угтаал сумын Засаг дарга 57.4 сая, Дэрэн сумын Засаг дарга 46.2 сая, Өлзийт сумын Засаг дарга 23.3 сая, Өндөршил сумын Засаг дарга 20.3 сая, Сайнцагаан сумын Засаг дарга 262.1 сая, Хулд сумын Засаг дарга 16.9 сая, Эрдэнэдалай сумын Засаг дарга 123.9 сая/*

*Шийдвэрлэсэн нь: Орлоготой холбоотой дээрх зөрчлүүдэд 2.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 36.8 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 551.9 сая төгрөгийн зөвлөмж өгч, аудитын явцад 131.8 сая төгрөгийн алдааг заруулсан.*

### 3.4.8 Зардал

*Хүснэгт №6 /сая төгрөг/*

Үзүүлэлт	2022		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Бараа, ажил үйлчилгээний зардал	21,452.8	19,730.5	-1,722.3
Татаас ба урсгал шилжүүлэг	1,091.1	1,013.9	-77.2
Хөрөнгийн зардал	15,535.5	11,103.5	-4,432.0
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл	2,785.5	1,109.3	-1,676.2
<b>Нийт дүн</b>	<b>40,864.9</b>	<b>32,957.2</b>	<b>-7,907.7</b>

*Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Зардлын бууралт нь орон нутгийн хөрөнгө оруулалтын 1,322.7 сая төгрөг, шилжсэн хөрөнгө оруулалт 288.7 сая төгрөг, төсөвт байгууллагын урсгал зардлаас 1,799.5 сая төгрөгийн зардлыг хэмнэж, төсөл сангуудын үлдэгдлийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланд зардлын данстай холбоотой нийт 355.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс материаллаг дүнтэй нийтлэг зөрчлийг дурдвал:*



- Төсвийн 314.9 сая төгрөгийг зарцуулахдаа зориулалт бус зардал зарцуулсан. /Сайнцагаан сумын 26.0 сая, Хулд сумын ОНХС 19.2 сая, Эрдэнэдалай сумын ЗДТГ 2.4 сая, Өлзийт сумын ЗДТГ 1.8, Сайхан-овоо сумын ЗДТГ 1.2 сая, Төрийн хэмнэлт 263.0 сая/
- Хууль эрх зүйн үндэслэлгүй болон норм нормативаас хэтрүүлэн нийт 37.4 сая төгрөгийг зарцуулсан. /Адаацаг сумын ЗДТГ 21.7 сая, Сайхан-Овоо ИТХ 10.5 сая, Адаацаг ИТХ 8.7 сая, Аймгийн ЗДТГ 13.3 сая, Дэрэн сумын ЗДТГ 21.7 сая, Цагаандэлгэр сумын ЗДТГ 21.0 сая, Эрдэнэдалай сумын ЗДТГ 41.4, Хулд сумын ИТХ 1.5 сая, Гурвансайхан сумын ЭЭС 3.5 сая, Эрдэнэдалай сумын ЭЭС 1.0 сая, Төрийн хэмнэлт 25.7 сая/
- Хуулийн дагуу суутгах 2.9 сая төгрөгийн НДШ болон ХХОАТ-ийг суутгаагүй. /СДОА 0.7 сая, ОНӨГ 1.1 сая, Өлзийт ЗДТГ 0.5 сая/
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчиж орон нутгийн төсвөөс төсвийн шууд захирагч нарт хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс 17.7 сая төгрөгийн урамшуулал олгож, Дундговь аймгийн 80 жилийн үйл ажиллагаанд зориулан үндсэн чиг үүрэгт хамааралгүй зардалд 194.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Мөн бусад төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн зөрчлүүдэд 77.0 сая төгрөгийн акт, албан шаардлагыг хүргүүлсэн.

Шийдвэрлэсэн нь: 134.9 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 30.5 сая төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 189.2 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлэн, 0.7 сая төгрөгийн зөвлөмж өгсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2022 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 40,864.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 40,864.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 22,543.9 сая төгрөгийг урсгал зардалд, 15,535.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 2,785.5 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 7,785.3 сая төгрөгийг улсын төсвөөс (Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан), 24,164.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,945.7 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос, 6,879.0 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 7,870.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 23,080.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 2,374.3 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос, оны эхний үлдэгдлээс 7,526.0 сая төгрөг, нийт 40,851.2 сая төгрөгийн санхүүжилтийг авсан нь батлагдсан төсвөөс 13.6 сая төгрөгөөр дутуу байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 32,957.1 сая төгрөг буюу 80.6 хувьтай байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-г нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсөв захирагчаас 993.7 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 776.7 сая, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан





хандив, тусламжийн орлого 1,690.0 сая, өмнөх оны үлдэгдлээс 64.7 сая, нийт 3,525.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс бараа ажил үйлчилгээний зардалд 2,468.9 сая, урсгал шилжүүлгийн зардалд 42.5 сая, хөрөнгийн зардалд 759.7 сая төгрөг буюу нийт 3,271.1 сая төгрөгийг зарцуулж 254.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг Төсвийн ерөнхийлөн захирагч Ц.Мөнхбат танд танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Д.Должинсүрэн нар гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 04 дүгээр сарын 05-ний өдрийн 1/439 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангаас нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 125,951.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1,259.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 881.7 сая төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Дундговь аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 288.7 сая төгрөгийн зөрчил илэрч дараах байдлаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвөөс төсвийн шууд захирагч нарт хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс 17.7 сая төгрөгийн урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоож, Дундговь аймгийн 80 жилийн үйл ажиллагаанд зориулан үндсэнүйл ажиллагаанд зориулан д захирагч нарт хууль эрх санхүүжилт олгосон зөрчлийн 60.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 134.0 сая төгрөгийг буцаан авахаар авлага үүсгэж залруулсан байна.



2. Мөн бусад төсвийн байгууллагууд төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 69.0 сая төгрөгийн бичиг хэрэг, шатахууны зардалд зарцуулсан зөрчилд албан шаардлага, 8.0 сая төгрөгийн бэлэг дурсгал, шаардлагагүй хөрөнгө бэлтгэсэн, хориглосон зардалд зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоож, буцаан төлүүлэхээр болсон байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Засаг дарга нь 2022 онд нийт 158 мэдээллээс 148 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод бүрэн, хугацаанд нь байршуулж, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

Дундговь аймгийн орон нутгаас санхүүжсэн түүвэрт хамрагдсан 31 байгууллага, дүгнэлт гаргах 42 байгууллага нийт 73 байгууллагын шилэн дансны цахим хуудсыг шалгалаа.

Шалгалтаар 2022 онд нийт 38,579.7 сая төгрөгийн 3,126 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас 7,716.4 сая төгрөгийн 722 мэдээллийг мэдээлээгүй, 177.3 сая төгрөгийн 49 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Иймд дүгнэлт гаргасан 15, түүвэрт хамруулсан 6 байгууллага буюу нийт 31 байгууллагад зөрчлийг таслан зогсоох хугацаатай албан шаардлага 12, зөвлөмж 9 хүргүүлэн ажилласан байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, “Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн журмын хүрээнд горим, сорил хэрэгжүүлээ. Горим сорилын үр дүнд 1,948.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 24.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 1,088.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 835.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Дундговь аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгээгүй. Харин Адаацаг, Хулд, Өлзийт, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Дэрэн, Дэлгэрцогт, Цагаандэлгэр зэрэг 8 сумын Засаг даргын Тамгын газар, Орон нутгийн хөгжлийн сан, Байгаль хамгаалах сан, Мал хамгаалах сангуудад хийсэн завсрын аудитаар нийт 982.3 сая төгрөгийн 70 алдаа зөрчил илэрч, 288.1 сая төгрөгийн 19 алдааг аудитын явцад залруулж, 21.2 мянган төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 373.8 сая төгрөгийн 32 зөрчилд хугацаатай албан шаардлага, 299.2 сая төгрөгийн 12 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна. Жилийн эцсийн аудитаар алдаа зөрчлийн хэрэгжилт 96.2 хувьтай байна.

##### **4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**



Өмнөх оны Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ажил сайжруулах 2 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	2		2				100
Нийт	2		2				100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлд дараагийн шууд тайлагнах аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

#### 5. Аудитын илрүүлэлт

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 39 төсвийн байгууллага, 17 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 32 тусгай зориулалтын сан, 15 сумын нэгтгэсэн тайлан, аймгийн Засаг дарга нийт 104 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 63 байгууллагыг аудитад хамруулан, 41 санхүүгийн тайланд дүгнэлт өгсөн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 63 байгууллагыг түүвэрт хамруулж, 41 байгууллагад дүгнэлт хүргүүлээ. Үүнд: “Өөрчлөлтгүй” 36, “Хязгаарлалттай” 5 /Цагаандэлгэр, Хулд Дэрэн, Эрдэнэдалай сумдын нэгтгэсэн санхүүгийн тайлан, Хулд сумын ЗДТГ/ дүгнэлт гаргасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 5,430.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,823.2 сая төгрөгийн 111 алдааг аудитын явцад залруулж, 183.4 сая төгрөгийн зөрчилд 70 төлбөрийн акт тогтоож, 1,480.6 сая төгрөгийн зөрчилд 121 албан шаардлага, 943.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 49 зөвлөмж өглөө.

Аймгийн нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 48 хувийг залруулагдаагүй, 52 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

#### Сумдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн төвлөрүүлэн захирагчийн 15 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаснаас “Өөрчлөлтгүй” 11, “Хязгаарлалттай” 4 /Цагаандэлгэр, Эрдэнэдалай, Хулд, Дэрэн сумдын нэгтгэсэн санхүүгийн тайлан/ дүгнэлт гаргасан байна.

Аудитаар нийт 793.5 сая төгрөгийн 44 алдаа, зөрчил илрүүлснээс 141.1 сая төгрөгийн 22 алдааг аудитын явцад залруулж, 9 зөрчлийг арилгах 64.1 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага, 588.3 сая төгрөгийн 13 зөрчилд зөвлөмж өгсөн.

Сумдын байгаль хамгаалах сан, мал хамгаалах сангийн санхүүгийн тайланг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитаар үзэж, шилэн дансны хэрэгжилт, татварын орлогыг нэр төрлөөр бүрэн төвлөрүүлж ажиллах талаар сумын Засаг дарга нарт зөвлөж ажиллалаа.

#### Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 39 байгууллагаас 15 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 24 санал дүгнэлт гаргаснаас “Өөрчлөлтгүй” 23, “Хязгаарлалттай” 1 /Хулд сумын ЗДТГ/ дүгнэлт өгсөн.



Аудитаар нийт 1,257.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 918.0 сая төгрөгийн 42 алдааг аудитын явцад залруулж, 40.2 сая төгрөгийн 35 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 285.8 сая төгрөгийн 63 зөрчилд албан шаардлага, 33.9 сая төгрөгийн 26 алдаа, зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 17 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг аудит хамруулснаас 16 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 1 санал дүгнэлт гаргахаас “Өөрчлөлтгүй” /Дундговь-Ус ОНӨААТҮГ/ гарсан байна.

Аудитаар нийт 553.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 264.4 сая төгрөгийн 20 алдааг аудитын явцад залруулж, 3.2 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 285.8 сая төгрөгийн 16 албан шаардлага хүргүүлсэн.

Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 32 тусгай сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа. Аудитаар нийт 2,822.2 сая төгрөгийн 96 алдаа, зөрчил илрүүлснээс 1,495.7 сая төгрөгийн 26 алдааг залруулж, 140.0 сая төгрөгийн 33 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 865.7 сая төгрөгийн 29 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 320.8 сая төгрөгийн 7 алдаа, зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 4.0 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илрүүлснээс 4.0 сая төгрөгийн алдааг залруулсан.

**Шийдвэрлэсэн нь:** Үндсэн хөрөнгийн дансны тайлант эцсийн үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан алдаа аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 6 зөрчил<sup>2</sup> илэрснээс зөрчил арилгах хугацаатай 3 албан шаардлага, хуулийн хэрэгжилттэй холбоотой 3 зөвлөмж өглөө.

#### 4.1 Албан шаардлага

1. Хулд сумын Засаг дарга, санхүүгийн алба нь 2021, 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараалан “Хязгаарлалттай” дүгнэлт авч, дотоод хяналтыг сайжруулаагүй.

Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.5.-д /Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх/, Төсвийн тухай хуулийн 14.2.10-д /Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх./, 36.6-д /Төв төрийн сан нь аймаг, нийслэлийн төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэлийн төрийн сан нь сум, дүүргийн төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ./ заасныг тус тус зөрчсөн.

**Шийдвэрлэсэн нь:** Хулд сумын санхүүгийн сахилга батыг сайжруулах талаар зөвлөмж, чиглэл өгч, дотоод аудитыг хэрэгжүүлж, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахад анхаарч ажиллах хугацаатай албан шаардлагыг Дундговь аймгийн Засаг даргад хүргүүлээ.

2. 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаарх ТЕЗ-ийн харьяа 8 байгууллагын 10 албан хаагчид хамааралтай эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



учирсан хохиролтой холбоотой 95.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д /өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх/ заасныг тус тус зөрчсөн зөрчсөн.

**Шийдвэрлэсэн нь:** ТЕЗ-ийн харьяа 8 байгууллагын 10 албан хаагчид хамаарал бүхий эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохиролтой холбоотой 95.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2 дахь хэсгийг хэрэгжүүлж ажиллах хугацаатай албан шаардлагыг Дундговь аймгийн Засаг даргаар дамжуулан СХДАА-д хүргүүлээ.

#### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:  
**Хууль, журмын хэрэгжилттэй холбоотой**

##### 1. Илрүүлэлт:

ТЕЗ-ийн 2022 оны нэгтгэсэн тайлан тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүнг өмнөх онтой харьцуулахад нийт зөрчил 1,002.6 сая төгрөг, залруулсан алдааны дүн 1,507.4 сая төгрөгөөр буурсан боловч төлбөрийн актын дүн 66.7 сая төгрөг, албан шаардлагын дүн 38.3 сая төгрөг, зөвлөмжийн дүн 399.8 сая төгрөгөөр тус өссөн үзүүлэлттэй байна. Төсвийн шинэчлэлттэй холбоотойгоор аудитын хамрагдсан төсөвт байгууллагын тоо 77 оор буурсан боловч залруулагдаагүй буюу материаллаг зөрчил нь 504.8 сая төгрөгөөр буюу 24.0 хувиар өссөн байна. Тайланд онд илэрсэн зөрчлийг агуулгаар авч үзэхэд нийт зөрчлийн дийлэнх буюу 23.9 хувийг бараа материалын данс, 17.5 хувийг нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй, 14.2 хувийг мөнгөн хөрөнгийн данстай, 12.7 хувийг хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил эзэлж байна.

##### Өгсөн зөвлөмж:

Төсөв захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрч буй зөрчлийн агуулгад дүн шинжилгээ хийж, гарсан зөрчлийг арилгах чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг тайлант хугацааны явцад хийж, жилийн эцсийн тайлан гарахаас өмнө хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллах

##### 2. Илрүүлэлт:

Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас зайлсхийж, хөрөнгө оруулалтыг хэсэгчлэн, өртгийг бууруулан /20 сая төгрөгөөс бага/, багц болгон хувааж шууд худалдан авалт хийдэг нийтлэг зөрчил илэрч байна.

##### Өгсөн зөвлөмж:

Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, шууд худалдан авах үнийн дээд хязгаараас давсан төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТ хууль, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах ажлыг зохион байгуулан, хяналт тавьж ажиллах;

##### 3. Илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчаас сумдын төсвийн захирагч нарт төсвөөс балансын урамшуулал олгох, үндсэн чиг үүрэгт хамааралгүй Дундговь аймгийн 80 жилийн үйл ажиллагаанд зориулан



сумын төсвөөс хөрөнгө зарцуулах тухай эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр чиглэл өгч орон нутгийн төсвөөс 211.7 сая төгрөг зориулалт бусаар зарцуулагдах нөхцөлийг бий болгосон.

Өгсөн зөвлөмж:

ТЕЗ харьяа байгууллагуудыг төсвийн зарцуулалт, нягтлан бодох бүртгэлт хөтлөлтэй холбоотой асуудлаар үндсэн чиг үүрэгт нь хамааралтай, хууль тогтоомжид нийцсэн арга зүй зөвлөмж өгч, санхүүгийн удирдлагаар хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

**Нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын алдааны нэгтгэл:**

Төсөв захирагчийн ангилал	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	1	4.0	1	4.0								
ТТЗ	22	160.2	8	38.7	14	121.5						
ТШЗ	45	939.2	16	62.8	29	876.4						
ОНӨААТҮГ	17	243.2	8	126.0	9	117.2						
ТЗС	26	1,476.6	3	4.4	23	1,472.1						
	111	2,823.2	36	235.9	75	2,587.3	0	-				

**Нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын зөрчлийн нэгтгэл :**

Төсөв захирагчийн ангилал	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	5	0.0			2	-	3	-				
ТТЗ	14	102.3	0	-	8	64.1	6	38.3				
ТШЗ	76	137.9	16	15.6	39	88.4	19	33.9	2			
ОНӨААТҮГ	16	104.6	1	1.7	14	102.8	0	-	1			
ТЗС	37	393.0	33	140.0	1	217.7	2	35.3	1			
<b>Нийт дүн</b>	<b>148</b>	<b>737.8</b>	<b>50</b>	<b>157.3</b>	<b>64</b>	<b>473.1</b>	<b>30</b>	<b>107.5</b>	<b>4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

**Нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын нийцлийн аудитын асуудал :**

Төсөв захирагчийн ангилал	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой</b>												
ТТЗ	1				1							
ТШЗ	20				11		9					
<b>Дүн</b>	<b>21</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>12</b>	<b>0</b>	<b>9</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой</b>												
ТТЗ	7	550.1	0	-		-	7	550.1				
ТШЗ	33	201.2	19	24.6	14	176.5		-				
ОНӨААТҮГ	4	184.5	1	1.5	3	183.0	0	-				
ТЗС	33	933.5		-	28	648.0	5	285.5				
<b>Дүн</b>	<b>77</b>	<b>1,869.3</b>	<b>20</b>	<b>26.1</b>	<b>45</b>	<b>1,007.5</b>	<b>12</b>	<b>835.6</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Нийт дүн</b>	<b>98</b>	<b>1,869.3</b>	<b>20</b>	<b>26.1</b>	<b>57</b>	<b>1,007.5</b>	<b>21</b>	<b>835.6</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

6.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

(сая.төгрөгөөр)

Д/д	Харьяа байгууллага	Аудитад хамрагдсан хэлбэр				Нийт зөрчил		Залруулсан		Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс			
		Дүгнэлт				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	
		Түүвэрт хамрагдсан	Өөрчлөлтгүй	Хязгаралтай	Сөрөг														Дүгнэлт өгөхөө татгалзсан
1	ТЭЗ		1			6	4.0	1	4.0	-	2	-	3	-					
2	ТТЗ		11	4		44	793.5	22	141.1	-	9	64.1	13	588.4					
3	ТШЗ	15	23	1		169	1,257.1	42	918.0	35	64	265.0	26	33.9				2	
4	ОНӨААТҮГ	16	1			40	553.4	20	264.4	2	17	285.8	-	-				1	
5	ТЭС	32				96	2,822.2	26	1,495.7	33	140.0	29	865.7	7	320.8				1
